



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/84

Хэрлэн сум

Гудамжны авто зогсоол тохижилтын ажлын  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний  
хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг, Тэмүүжингийн гудамжны авто зогсоол тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичиг:	Ц.Мягмар-Ариунаа	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Э.Элбэг-Эрдэнэ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2024

23101027